

Санхүүгийн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт

Хот байгуулалт, хотын стандартын газар

2025.07.09

Д/д	Илэрсэн асуудлууд	Акт	Зөвлөмж	Биелэлт
1	Тайлант 2024 онд Хотын стандартын газраас шилжин ирсэн 19,698.5 мянган төгрөгийн өртөгтэй, Хотын 42 стандартыг стандартчлал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өнөөдрийг хүртэл бүртгүүлээгүй байна.		19,698.5	Стандарт хэмжил зүйн газарт 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/722 дугаар албан бичгээр тодруулга хүсэж, албан бичиг илгээгээд байна.
2	Тайлант онуудад байгууллагын төсвөөс 2 жил дараалан худалдан авах ажиллагааны АЗ сургалтанд хамрагдан тэнцээгүй байгаа 3 албан хаагчид 510.0 мянган төгрөгийн зардал гарган төсвийг үр ашгийг зарцуулсан зөрчил илэрлээ.	510.0		Худалдан авах ажиллагааны сургалтанд хамрагдсан боловч шалгалтандаа унасан 3 албан хаагчаас төлбөрийг буцаан авч Нийслэлийн Дотоод аудитын албаны дансанд тушаасан.
3	Тайлант 2023 оны 10-р сард бараа бараа материалын тайланг гаргаж ажиллаагүй байна.			2024 оноос бараа материалын тайланг сар бүр гарган ажиллаж байна.
4	НХААГ/20240102281 дугаартай газар хөдлөлийн чичирхийлэл хэмжигч төхөөрөмж худалдан авах ажилд Өү Ти Сольюшн ХХК шалгарч 175,130.0 мянган төгрөгийн гэрээг байгуулсан байна. Тус гэрээнд нэг бүр нь 87,656.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг, нийт 175,130.0 мянган төгрөгийн хөрсний хурдатгал хэмжигч багажны иж бүрдэл нийлүүлсэн байхад данс бүртгэлд тусгаагүй, тус хөрөнгийг эрх бүхий байгууллага, НӨХГ-ын шийдвэргүйгээр Одон орон геофизикийн хүрээлэнд шилжүүлсэн зөрчил байна.	175,130.0		Газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 03-ний өдөр А/40 дугаартай тушаалаар төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг шалгаж хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж газар хөдлөлтийн чичирхийлэл хэмжигч төхөөрөмжийг бүрэн бүтэн, эвдрэл гэмтэлгүй, үзүүлэлт нь шаардлага хангаж байсан тул 100 хувийн саналаар хөрөнгийг 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авсан. Байгууллагын данс бүртгэлд тусгах ажил хийгдэж байна.
5	Ибарилга Нийслэлийн хот байгуулалтын цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн ажилд Газрын даргын 2024 оны А/65 тушаалаар 2024.10.15-ны өдөр үнэлгээний хороо байгуулан төсвийн урсгал зардлаас 200,000.0 мянган төгрөгөөр нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгчээр Смарт дата ХХК шалгарч 2024.11.20-ны өдөр НХБХСГ/202401020002 дугаартай, 196,500.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж, 2024.12.25-нд ажлыг 100 хувь гүйцэтгэсэн гэж дүгнэн барьцаа 10 хувь авч үлдсэн санхүүжилтийг олгосон. Гэтэл ажлын даалгаварт хийгдэх ажлууд "3-т барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ, паспортжуулалт хийх үйлчилгээ нэмэх" гэж тусгасан байтал хөгжүүлэлт хийсэн систем нь Барилга байгууламжийг газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварын үнэлгээ, паспортжуулалт хийх үйлчилгээ нэмэх гэж үүрэг өгсөн байхад барилгын дүгнэлтийн цахим архивт баяжилт хийсэн гэх цонхийг төстлэх шатандаа байгаа бөгөөд өнөөдрийг хүртэл ашиглалтанд оруулоогүй байна. Гэтэл ажлын гүйцэтгэл бүрэн дуусаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон зөрчил байна		200,000.0	Барилга байгууламжийн паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт олгох үйлчилгээг eBarlga хот байгуулалтын цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн ажлын хүрээнд иргэн, хуулийн этгээд www.ebarlga.ub.gov.mn геопорталаар ДАН танилт нэвтрэлтийн системээр дамжуулан нэвтрэх цахимаар хүсэлт илгээх, дүгнэлт гаргах шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой байдлаар зохион байгуулж цахимжуулсан. Барилга байгууламжийн паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт олгох үйлчилгээг тус хэлтсийн албан хаагчид ebarlga хот байгуулалтын цахим системийн дотоод удирдлагын системээр нэвтрэн орж шийдвэрлэхдээ дүгнэлт хийсэн барилгын 55 төрлийн үзүүлэлтээр бүртгэх боломжтой байдлаар хөгжүүлж, үзүүлэлтийг админ эрхээс шинэчлэх, өөрчлөх, хуссан үзүүлэлтээ нэмэх байдлаар хөгжүүлсэн. Харин дүгнэлт хийсэн барилга байгууламжийн паспортжуулалттай холбоотой мэдээллийг оруулах, шаардлагагүй тохиолдолд бүртгэх үзүүлэлтүүдийг өөрчлөх, хүсэлт шийдвэрлэлтийн шат дамжлагыг солих эрхийг тухайн чиг үүргийн хэлтсийн хүсэлтийн дагуу өөрчлөх боломжтой. Ажлын даалгаварын дагуу ажлыг хугацаанд нь иж бүрэн хүлээн авч, 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санхүүжилтийг бүрэн олгосон.

10	Тайлант 2023, 2024 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгүй, тайлангүй байна.			2025 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан бөгөөд алдааг давтан гаргахгүй ажиллана.
11	Тайлант 2023 оны Квант сервис ХХК-аас 4,488.0 мянган төгрөгөөр 2 ширхэг скайнер, 2024 онд Мета дата ХХК-аас 4,699.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Эн ди ти эс ХХК-аас 13,385.2 мянган төгрөгийн бетон бат бэх тодорхойлогч алх, нийт 22,572.2 мянган төгрөгийн хөрөнгийг цахим дэлгүүлээс худалдан аваагүй, үнийн санал авч харьцуулалт хийгээгүй шууд худалдан авалт хийсэн байна.	22,572.2		Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.2.Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно. Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар Шууд худалдан авч болох бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар 20 сая төгрөг байхаар тогтоосон. Энэ хууль, тогтоолын дагуу 20 сая төгрөг даваагүй тул 2023 оны 4,488.0 мянган төгрөг 2024 оны 18,084.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авалт хийсэн. Цахим дэлгүүрт бичиг хэргийн материал, тоног төхөөрөмж байдаггүй тул эдгээрийн байршуулж өгөх хүсэлтийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/363 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.
12	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа 3 ажлын нийт 345,031.5 мянган төгрөгийн дүнтэй Зураг төсөл консалтинг ХХК-ийн гэрээний хугацаа 2022.03.28-ний өдөр дууссан байхад магадлалын нэгдсэн дүгнэлт гарахыг хүлээж байгаа шалтгаанаар өнөөдрийг хүртэл гэрээ сунгаагүй, бүртгэлд тусгаагүй, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсан байна.	345,031.5		Манай газраас 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01-01/187 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргад тус ажилд эксперт томилж өгөхийг хүссэн албан бичгийг хүргүүлсэн. 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/0103 дугаартай албан бичиг, 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 09/12 дугаартай албан бичиг, 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 01/274 дугаартай албан бичиг, 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/595 дугаартай албан бичгээр тус тус мэдэгдэл хүргүүлсэн. Мөн 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/593 дугаартай албан бичгээр Барилгын хөгжлийн төвөөс дээрх ажлууд нь магадлалын нэгдсэн дүгнэлт гарсан эсэх дээр тодруулга ирүүлэх тухай хүсэлтийг хүргүүлсэн. 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01/1576 дугаартай албан бичгээр Барилгын хөгжлийн төвөөс хариу албан бичиг ирүүлсэн. Тус албан бичигт Хяналтын экспертүүд томилогдон 100% шийдвэрлэсэн бөгөөд магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах бичиг баримтыг зураг төсөл гүйцэтгэгч ирүүлээгүй тухай тодруулга ирүүлсэн. 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 53/25 дугаартай албан бичгээр Зураг төсөл консалтинг ХХК нь дээрх 3 ажлыг 2025 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор магадлалын нэгдсэн дүгнэлтийг гаргуулан хүлээлгэн өгөх тухай албан бичиг хүргүүлсэн.

Нийт дүн

ХБХСГазрын дарга
ЗУХэлтсийн дарга
ХОЗМТХэлтсийн дарга
ББЧСХэлтсийн дарга
ДТДХХХэлтсийн дарга
ХСХХэлтсийн дарга
Ерөнхий нягтлан бодогч

Баярсайхан
Д.Дашцэцэг
Т.Цамц
Ж.Батсайхан
Ч.Бадамханд
Д.Нямдаваа
Б.Болормаа